

## УЛАМЖЛАЛТ БОЛОН ХАРИЗМАТ ЛЕГИТИМЧЛЭЛЭЭС ХУУЛЬ ЁСТ ЛЕГИТИМЧЛЭЛ РУУ

**Г.ЦЭНД-АЮУШ**

*Улс төр судлалын тэнхимийн дэд профессор, доктор*

**Д.СҮХБОЛД**

*Улаанбаатар эрдэм их сургуулийн багш,  
Улс төр судлалын тэнхимийн докторант*

*“Хаан хүн жаргахдаа төрийнхөө сайнд жаргаюу,  
Харц хүн жаргахдаа хааныхаа сайнд жаргаюу”*

*/Чингис хааны билиг сургаалнас/*

**Түлхүүр үг:** Засаглал, засаглалын хэлбэрүүд, легитимт чанар, хууль ёсны засаглал, төрт ёс

**Хураангуй:** Засаглалын легитим шинж гэсэн ойлголтыг задлан шинжилж М.Веберийн тодорхойлсон уламжлалт, харизмат, хууль ёсны гэсэн засаглалын легитимийн хэлбэрүүдэд улс төрийн сэтгэлгээний үүднээс дүгнэлт тодорхойлолт өгч, монголын улс төрийн систем хууль ёст легитим шинжээ хадгалахын чухлыг өгүүлэв.

\* \* \*

Тухайн засаглалыг олон түмэн зэрэгээр үнэлж, хүлээн авах, удирдуулах, захирагдахыг хүлээн зөвшөөрөх явдлыг засаглалын легитим<sup>1</sup> шинж гэдэг. Бүр тодруулбал, легитим гэдэг нь иргэдийн зүгээс засаглалд хандах үнэлгээний шинжтэй бөгөөд тухайн засаглал нэр хүндтэй, тогтвортой, үр ашигтай, хүсүүштэй байх утгыг илэрхийлнэ.

Зарим тохиолдолд легитим гэсэн франц гэсэн үгийг<sup>2</sup> “хууль ёсны”, “хуульчлагдсан” хэмээн орчуулж хэрэглэх явдал байдаг ч энэ орчуулга нь легитим гэдэг ухагдахууны агуулгыг бүрэн гүйцэт илэрхийлж чаддаггүй. Учир нь хууль ёсны гэдэг нь хуулиар дэмжигдэж баталгаажсан, хуульд нийцэж байх гэсэн утгыг илэрхийлэх бол легитим гэдэг нь дээр дурдсанчлан засаглалд хандах үнэлэмжийн шинжийг илүүтэй агуулсан ойлголт юм.

Хууль ёсны засаглал нь заавал легитим шинжтэй байх албагүй. Өнөөдөр үндсэн хуульд зааснаар Монгол улс нь парламентын засаглалтай улс. Энэ нь хууль ёсны шинжтэй. Харин парламент нь легитимийн хувьд хямарсан байдалтай, олон түмний дэмжлэг итгэл найдварыг дааж чадахгүй байна. Шууд хэлбэл, монголын улс төрийн систем олон түмэнд хүлээн зөвшөөрөгдөх чадвараа алдаж<sup>3</sup> засаглал нь легитимийн хямралд орсон гэж үзэж болно.

Түүхэнд хууль ёсны засаглал нь эрх баригчид өөртөө нийцтэй хууль батлаж, түүнийгээ хуулиар далайлгаж дарангуйлах хэрэгсэл болгож байсан нь цөөнгүй. Хууль ёс болон легитим шинж нь салшгүй холбоотой ойлголтууд мөн. Легитим шинж гэдэг бол засаглалын нэр хүнд, уг засаглалыг хүн амын дийлэнх олонх хүлээн авч дэмжиж байгаа байдал, тэрчлэн тухайн орны нөхцөл байдалд улс төрийн нийтлэг үнэт зүйлд нийцэн тохирч байгаа байдлыг илэрхийлнэ.

Засаглалын легитимийн үзэл баримтлалыг боловсруулахад Германы судлаач Макс Вебер ихээхэн хувь нэмэр оруулсан байдаг. Тэрээр захирах захирагдах, сэдэл, шалтгаанаас хамаарч легитим шинжийн гурван үндсэн хэлбэр байна гэж үзсэн. Үүнд:

- **Уламжлалт легитим шинж** /Эрт дээр үеэс уламжилж ирсэн дэг журам, заншлын эрхзүй, хууль

<sup>1</sup> МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” 2001 96-р тал.

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Монголын улс төрийн системд лидерийн цус сэлбэлт хийгдэхгүй нийгмийн зүгээс ирж буй шаардлагад систем идэвхтэй харилуу өгч дасан зохицож чадахгүй, удаа дараалан засгийн газар огцорч, энэ хэрээрээ нийгэм эдийн засаг тогтворгүй болж засаглалын хямрал гаарч буй энэ тохиолдолд иргэдийн улс төрөөс залхах, улс төрийн намууд болоод төр засагт тоомсоргүй хандах, хэн нь ч гарсан адилхан гэж үзэх хандлага ихсэж энэ нь сонгуульд үл оролцох хэлбэрээр илэрч байна. МУИС “Политологи” сэтгүүл 2015 “Бүгд найрамдахчуудгүй Бүгд найрамдах улс” Д.Сүхболд

ёсыг хөдөлшгүй бат бэх бөгөөд ариун шударга гэж үзэх итгэл үнэмшил, түүнд тулгуурлаж байгаа засаглалын ноёрхлыг хэлнэ/

- *Харизмат' легитим шинж* /Харизмат засаглал нь олон түмнийг өөртөө татах, манлайлах удирдагчийн онцгой авьяас чадвар, итгэл үнэмшил дээр тулгуурладаг/
- *Хууль ёсны буюу ардчилсан легитим шинж* /Хууль ёсны буюу ардчилсан хэм, хэмжээний дагуу бүрэлдэн бий болсон эрх зүйт төрийг хамгийн зөв, шударга гэж үзээд түүнд засаглуулахыг хүлээн зөвшөөрсөн олон түмний итгэл/

Энэхүү өгүүллэгээр М.Веберийн боловсруулсан легитимийн үзэл баримтлалыг давтан нурших зорилго тавиагүй, харин түүний засаглалын легитимийг ангилсан дээрх гурван ангиллыг загвар болгож уламжлалт болон харизмат легитимчлэл нийгэм улс төрийн сэтгэлгээний түүхэнд хэрхэн яаж, ямар үндэслэлээр хэрэгжсэнийг судлаачийн зүгээс тодруулж дэлгэрүүлэхийг эрмэлзсэн болно.

Ингэснээр хууль ёсны легитим шинжийн ач холбогдлыг илүүтэй үнэлэх боломжтой болох юм.

### 1. Уламжлалт легитим шинж

Уламжлалт легитим нь харьцангуй тогтвортой, урт удаан хугацаанд оршин тогтнож ирсэн бөгөөд ялангуяа эртний ази дорно дахины улс орнуудад түгээмэл ажиглагддаг. Иймээс энэхүү өгүүллэгт эртний төрт ёсны олон зуун жилийн түүхтэй эртний Энэтхэг, Хятад, Монгол зэрэг улсуудыг засаглалын уламжлалт легитим шинжийн жишээ болгон авлаа.

Эртний Энэтхэг, Хятад, Монгол зэрэг улсуудад эзэн хаад, захирагчдаа бурханчлан, тэнгэрчлэн шүтэж дээд тэнгэрээс заяатай гэж үзэхээс гадна нийгэм улс төр, хүмүүсийн амьдралыг цаанаас нь зохицуулж байдаг далдын ид шид дом, шашин шүтлэгийн онгод тэнгэр байдаг гэдэгт итгэсээр иржээ.

Тухайлбал, эртний Энэтхэгт хүмүүсийн ахуй амьдралыг зохицуулагч гол механизм нь бурхан тэнгэр гэсэн хандлага ихэд байсан ба тэр нь *Рит*, *Дхарм*, *Дамд*, *Карма* гэсэн ойлголтуудаар илэрч байв.

- *Рит* гэдэг нь бурхны дээд ертөнц, бидний амьдарч буй ертөнцийг бүхэлд нь зохицуулагч дээд хүч /Цаанаасаа заяасан юм/
- *Дхармыг* зарим ном зохиолд цээрлэл үзүүлэх буюу ял шийтгэл гэсэн утгаар тайлбарласан байдаг. Үнэндээ Ритийг зөрчсөнөөс болж хүлээх ёстой хариуцлага буюу ёс суртахууны хэм хэмжээг заасан ойлголт юм. /дотоод сэтгэхүйд нь ухамсарлуулсан/ Мөн нэгэнт заяасан төөргийг зөрчиж болохгүй гэсэн ойлголт энэхүү дхарм гэсэн ойлголтонд багтдаг. Үүгээрээ хүмүүсийн харилцааг зохицуулж ирсэн нэг ёсондоо хуулийн хэм хэмжээ, ёс суртахууны хэм хэмжээ хоёрыг хоёуланг нь агуулсан ухагдахуун, нөгөө талаас үүрэг, хариуцлага гэдгийг бас агуулсан. Тийм ч учраас эртний Энэтхэгт хувь хүний дхарм, гэр бүлийн дхарм, багш шавийн дхарм гэсэн ойлголтууд хүчтэй хэрэглэгдэж байжээ.
- *Дамд* нь ял шийтгэлийн тухай ойлголт. Нөгөөтэйгүүр Дамд нь төр засаглалын зүгээс албадлагыг явуулах онцгой эрх мэдлийг өөртөө агуулж байсан.
- *Карма* нь хүний хойт настай холбоотой ойлголт

Хэрвээ хүн энэ яваа насандаа Рит болон Дхармыг удирдлагаа болгож зөв зохистой замаар явж чадахгүй бол Дамдын ялд унасаар Карма буюу хойт насандаа зовлон зүдгүүрийн туйлыг эдэлнэ гэсэн энгийн логиктой.

Цаашлаад эртний Энэтхэгийн нийгэм улс төрийн харилцааг олон зуун жил зохицуулж ирсэн үзэл санаа бол кастын систем буюу брахманизмын тухай үзэл санаа бөгөөд МЭӨ 3 дахь мянган жилийн тэртээ бичигдсэн болов уу хэмээн тооцогддог “Дхармашастра” гэдэг зохиолд энэ талаар тодорхой бичигдсэн байдаг. Эртний Энэтхэгт МЭӨ мянгаад жилийн тэртээгээс брахманизмын үзэл санаа ноёрхож байсан үе дуусаж МЭӨ 6-р зууны үеэс буддизмын үзэл санааны эрин үе эхэлсэн түүхтэй. Энэхүү *Рит* болон *Дхармыг* эртний Энэтхэгчүүд хамгийн шударга ёс хэмээн тооцож, харин брахманизм, буддизмын үзлийг бидний нийгэм улс төрийн харилцааг зохицуулагч төгс сургаал гэж үзээд тэдгээрт захирагдаж болон захирагдахад бэлэн байжээ.

Төрт ёсны олон зуун жилийн түүхтэй эртний Хятадын улс төрийн сэтгэлгээнд ч гэсэн төрийн засаглалын уламжлалт легитимийн хэлбэр ихээхэн үүрэг гүйцэтгэж иржээ. Тухайлбал <sup>5</sup> эртний Хятадад тэнгэрийн тухай үзэл хүчтэй байсан ба эзэн хаанаа тэнгэрийн хүү хэмээн ойлгож эзэн хаандаа захирагдана гэдэг нь тэнгэрт захирагдаж байна хэмээн итгэж байв. Эртний хятадын их сэтгэгч Күнз / МЭӨ 551-479/ эзэн хааны засаглал бурхнаас эхтэйг хүлээн зөвшөөрөөд<sup>6</sup> улс орныг зан заншил, ёс суртахуунаар дамжуулан удирдах ёстой гэжээ.

<sup>4</sup> Грек хэлний “Charizma” Бурхан тэнгэрээс олгосон онцгой чадвар гэсэн утгатай МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” 2001 97-р тал

<sup>5</sup> Ерөөс тэнгэрийг шүтэх ёс нь нийт Евразийн буюу дэлхийн олонх улс түмний дээдлэн үздэг нийтлэг эрхэм шүтлэг байсан. Ш Бира

<sup>6</sup> МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ 2001 37-р талыг үз

Күнзийн сургаалийг 3 үндсэн хэсэгт хувааж болно. Үүнд:

- ✓ Тэнгэрийн тухай
- ✓ Төрийн тухай
- ✓ Ёс суртахууны тухай

Түүнийхээр тэнгэр гэдэг нь хийсвэр зохицуулагч хүчин, мэргэн ухаан зүй зохис, үнэмлэхүйн чин шударгын илэрхийлэл болж байдаг. Тиймээс тэнгэртэй харьцах хүний асуудлыг Күнз гол болгосон. Тэнгэр нь хүмүүсийн амьдралыг дээрээс харан зохицуулж байдаг. Тэнгэр бол агуу зүйл. Тэнгэр хүмүүсийг шагнадаг бас шийтгэдэг. Түүнийхээр төр нь тэнгэрийн бүтээл учраас төрд, эзэн хаанд захирагдана гэдэг нь тэнгэрт захирагдаж байна гэсэн үг. Күнзийн ёс суртахууны үзэл дараах ойлголтуудаас бүрддэг.

Үүнд:

*Ли-ёс горим зан заншил*  
*Жэнь-хүнлэг энэрэнгүй*  
*Синь –үнэнч шударга*  
*И- үүрэг хариуцлага*

Түүнийхээр хүн бүр өөрийн нэр төрөө эрхэмлэж, үүргээ ухамсарлах ёстой. Хүмүүс үнэнч шударга ёс заншлаа дээдэлдэг, үүрэг хариуцлагатай, хүнлэг байж чадвал улс орон хөгжих томоохон түлхэц болно. Улс орныг чанга хатуу хуулиар биш, ёс суртахуун уламжлалаар дамжуулж удирдах ёстой гэжээ. Күнзийн сургаалтай хүчтэй өрсөлдөж байсан үзэл баримтлал бол “Шан мужийн захирагчийн шастир” гэсэн бүтээлээрээ алдаршсан Гансунь Ян / МЭӨ390-338/ буюу Шан Яны үндэслэсэн легилизмын номлол юм. Легилизм нь улс орны эмх замбараагүй байдлыг эцэс болгохын тулд чанга хатуу хууль, журмыг тогтоож, хүн болгоныг толгой дараалан хянах ёстой гэсэн үзлийг хатуу баримталжээ.

Тэд “Фа” буюу хууль ёс гэсэн ойлголтыг гаргаж тавиад нэг жил хуулийг удирдлагаа болгож чадсан улс улс орон 10 жил оршин тогтнож чадна, 10 жил хуулийг удирдлагаа болгосон улс 100 жил баттай оршин тогтнож чадна, харин 100 жил хуулийг удирдлагаа болгож чадвал тэр улс мянган жилээр ч орших чадалтай болно хэмээн үзжээ. Мөн хуулийг зөрчсөн хүмүүст хүлээлгэх ял шийтгэлийн хатуу системийг боловсруулсан нь давхар хариуцлагын тогтолцоо бөгөөд энэ нь ямарваа хүн гэмт хэрэг хийвэл гэр бүлийн гишүүдийг нь давхар шийтгэх тогтолцоо юм.

Күнзийн болоод Легилизмын үзэл баримтлал нь эртний Хятадыг их гүрэн болоход өөр өөрийн хувь нэмрээ чамлалтгүй оруулсан ба тухайн үедээ төр засгийг удирдах үзэл суртлын легитим шинж нь болж байв. Цаашлаад Эртний Хятадад мөнхийн шударга ёс гэсэн ойлголтыг “Дао” хэмээх ойлголтоор төлөөлүүлж байжээ.

Даосизмыг үндэслэгч нь Лао дань –Ли эр, бичгийн нэр нь Лао-Цзы. Лао-Цзы эртний Хятадын Чу улсад МЭӨ 604 онд төрсөн. Бас л Күнзтэй өрсөлдөхүйц сургаалийг боловсруулсан нь Даосизм юм. Түүний гол бүтээл нь Дао болон Дэ-гийн тухай. Даогын сургаал Хятадын улс төр, нийгэм, философийн түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэсэн.

Дао хэмээх дүрс үсэг нь 2 хэсгээс бүрддэг. Үгчлэн орчуулбал, хүмүүсийн явах зам мөр гэсэн утгатай. Мөн нийтийн зан мөр үнэмлэхүй дээд жам ёс гэсэн санааг агуулдаг. Дао үзэгдэхгүй дуу авиа гаргахгүй түүнд хэлбэр дүрс байхгүй, тэмтрээд баригдахгүй. Бүх зүйл хувирч өөрчлөгддөг. Харин тэдгээрийг зохицуулагч хууль хувиршгүй мөнхийн тэр нь Дао. Орчлон ертөнцөд оршин тогтнох бүх юмс үзэгдэл Даогын жамыг даган захирагддаг. Дао нь нэг хууль ёс биш бөгөөд Дао хувьсан өөрчлөгдөх ертөнцийн үл хувирах анхдагч үндэс. Даогын үйлчлэл хязгааргүй, тэрээр хаа сайгүй урсна. Орчлон ертөнцийг өөртөө багтаан шингээж, тэтгэн дэлгэрүүлэх агуу их Даогаас ангид орших зүйл нэгээхэн ч үгүй. Хүн зөв зохистой үнэн бат замаар явъя гэвэл Даогын жам ёсыг дагах ёстой. Байгаль дэлхий бүхэлдээ Даогын хуулинд захирагдаж түүний жамаар явдаг тул Даог дагана гэдэг нь байгалийг дагаж байгальд дасан зохицож амьдарна гэсэн үг.

Өдгөө орчин цагийн хятад улсад эрт дээр үеэс нь уламжлагдан ирсэн дээрхи Күнзийн ёс суртахуун, Легилизмын чанга хатуу хууль цааз нь төрийн бодлого үйл ажиллагаа болоод ард иргэдийнх нь ухамсарт нь тодорхой байр суурийг эзэлсээр байна.

Харин эртний монголчуудын засаг төрийн уламжлалт тогтолцооны легитим шинжийн илрэл нь нэг хүний засаглалыг ардчилалтай хослуулах байсан ба улс төрийн гол үзэл суртал нь “Шүтэн захирагдах ёс” болоод “Мөнх тэнгэрийн үзэл буюу Тэнгэрчлэл” байв. Мөнх тэнгэрийн үзэл болон тэнгэрчлэлийн үзлийн талаар монголын нэрт эрдэмтэн, академич Шагдарын Бира гуай дорвитой судалгааг хийсэн байдаг.

Эзэн хаадынхаа гарал үүслийг тэнгэр бурхнаас улбаатай гэж ойлгож байсан эртний улсуудын нэгэн адил монголчууд өөрсдийн хаант төрийг мөн л ер бусын дээдийн ариун гэгээн гаралтай хэмээн өргөмжилж байв.

<sup>7</sup> МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ 2001, 37-р тал

“Монголын анхны төрт улс болох Хүннү нар эзэн хаанаа “Тэнгэрээс заяат”, Шаньюй /Мао-тун/, “Тэнгэр газар. Нар сараас заяат их Шаньюй /Лаошан/ гэх зэргээр өргөмжилж байжээ.

Цаашлаад монголын төр тэнгэрлэг язгууртай болох тухай өвөрмөц үзлийг “Нууц Товчоо” –нд яруу тодоор тодорхой өгүүлсэн байдаг. Монголын “Нууц товчоо”-ны эхний хэсэгт “ Чингис хааны язгуур нь дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ- чоно” болох талаар домогчлон өгүүлсэн нь Чингис хааныг жирийн хүн бус, дээд тэнгэрийн хөвгүүн гэдгийг баталхад чиглэжээ. Ийнхүү Чингис тэргүүтэй хаадын удам угсаа Мөнх тэнгэрээс үүдэлтэй гэсэн гэсэн үзэл санаа улам бүр хүчээ авч энэ нь 13-р зуунд байгуулагдсан Их Монгол улсыг бэхжүүлэх гол үзэл суртлын легитим болоод зогсохгүй төр улсаа хуульчлан зөвтгөх, улмаар мөнх тэнгэрийн хүчээр ертөнц дэлхийг захирах эрхээ ч хуульчлан үндэслэх улс төрийн үзэл суртал болтлоо хөгжиж чаджээ. Мөнх хөх тэнгэр болоод тэнгэр язгуурт хааны засаглалыг эртний монголчууд хамгийн төгс удирдлага гэж үзээд түүнд засаглуулж болон засаглуулахад бэлэн байсан нь <sup>9</sup> “Үнэмлэхүйн дээд Мөнх Тэнгэр минь”, “Үнэнийг үнэн болгож заяасан Тэнгэр минь”, “Хамгийн дээд Мөнх тэнгэр минь”, “Хамаг бүгдийг заяасан Тэнгэр минь”, “Хөдлөхийн дээд Хөх Мөнх Тэнгэр минь”, “Хөдлөх бүгдийг заяасан Тэнгэр минь” гэх мэтээр тэнгэрийг олон зууны турш магтан тахисаар ирсэн явдлаар тодорхойлогдоно.

Өдгөөгийн монголчуудын өөрийнхөө сайн сайхан яваагаа, амжилт, алдаа оноогоо төр засагтайгаа холбон төрийн минь буян, төрийн минь сүлд өршөө, төр түмэн нүдтэй, төр төмөр нударгатай гэх мэтээр ярьдаг нь ч дээрх тэнгэрлиг язгуурт төртэй байсантай нь шууд холбоотой. Тэнгэрлиг язгуурт төр нь ч үүргээ сайн биелүүлж ард олныг мөр бүтэн гэдэс цатгалан байлгаж, ачлал энэрлийг үзүүлж бурууд хатуу, зөв шударга урамшууллыг хүртээж, амар амгаланг тогтоож байсны хэрээр ард иргэд нь ч төр засаг, эзэн хаанаа тэнгэрчлэн шүтэж нэг ёсондоо шүтэн захирагдах ёс монголын нийгэмд ноёрхож байв. Энэ нь угтаа дорно дахины деспотизмын онцлог бөгөөд эзэн хаан нь бурхан тэнгэрээс гаралтай учир асар их нэр хүндтэй, олон түмнээр хүрээлүүлсэн байдаг бол өрнө дахины деспотизмын онцлог нь ард иргэдээ үг дуугуй, хүчээр захиран дарангуйлахад оршино. /Эртний Рим/ Германы философич Ф.Гегелийн хэлсэнээр өрнө дорны деспотизмын гол ялгаа нь энэ болой. Чухамхүү дорно дахины деспотизмын гол онцлог нь <sup>10</sup> “Шүтэн захирагдах” ёс байжээ. Монголчууд үе үеийн төрийн тэргүүнээ дээдлэн хүндэтгэж, дээд язгууртан, тэнгэр заяат хэмээн шүтэж, тэрхүү шүтлэгээ дагаж, захирах, захирагдах ёсыг чанд сахиж иржээ. Энэхүү “Шүтэн захирагдах ёс” зөвхөн хаан, харц ардын хооронд төдийгүй тухайн үеийн монголын нийгмийн бүхий л хүрээнд нэвтэрч монгол түмний оршин тогтнох ёс суртахууны нэгэн үнэлэмж болтлоо хөгжжээ. Их эзэн богд Чингис хаан XIII зуунд монгол туургатнаа нэгтгэсний дараа дараах айлтгалыг хийсэн байдаг. Үүнд: “ Хүү нь эцгээ хүндэтгэхээ, эцэг нь хүүгээ ачлахаа, эр нөхөр нь эхнэртээ итгэхээ, эхнэр нь нөхрийнхөө үгийг авахаа, багачууд нь ахмадыгаа хүлээн зөвшөөрөхөө, баян нь ядуугаа тэтгэхээ, дорд хүмүүс нь дээдчүүлдээ хүндэтгэл үзүүлэхээ больсоноос газар сайгүй яахын аргагүй эмх замбараагүй байдалд идэгдэж, эцэс төгсгөлгүй дур зоргоороо авирлах явдал ноёрхох болсон байв. Би үүнийг эцэс болгож, хууль ёс, дэг журмыг тогтоосон болой”<sup>11</sup> хэмээжээ. Бас<sup>12</sup> “Их засаг” хуулинд “шүтэн захирагдах” ёсыг хуульчилсан байдаг. “ Хөвгүүн хүүхэд, хүүхэд, эцэг эхээ үл хүндлэгсэд, дүү нар багачууд, ах ихсээ үл хүндлэгсэд, гэргий нь эрийнхээ зарлигийг үл дагагсад болон харъяатан захирагчдаа үл хүндлэгсдийг хүндээр шийтгэмой” гэжээ. Монгол ёсоор бол үр хүүхэд нь эцэг эхээ, залуу үе нь ахмад үеэ, эхнэр нь эр нөхрөө, харц ард нь хаад ноёдоо, шавь нар нь номын багшаа шүтэж, тэрхүү шүтлэгээ дагаж үг дуугүй захирагдах ёстой аж.

Иймээс “Шүтэн захирагдах” ёс нь монгол болоод дорно дахины нийгмийн тогтолцооны үндэс болоод зогсохгүй бас улс орныг удирдах засаглалын легитим шинж нь болж байжээ.

Өдгөөгийн монголд засаглал нь легитимийн хямралд орж улс орныг удирдан жолоодох засаглалын оновчтой хувилбарууд яригдаж буй энэ үед язгуурын монгол төрийн уламжлал, үнэт зүйлсийг дорвитой судлах асуудлыг зөнд нь орхиж үл болно. Эртний Энэтхэгийн брахманизмын болоод буддизмын үзэл, Эртний Хятадын Күнзийн болоод легилизм, даогийн суртлууд одоог хүртэл Энэтхэг,<sup>13</sup> Хятадын улс төрийн систем болон засаглалд нь тодорхой байр суурийг эзэлсээр ирсэн шиг Эртний монголчуудын Мөнх тэнгэрийн үзэл болоод тэнгэрчлэх үзэл, шүтэн захирагдах ёс нэг хүний засаглалыг ардчилалтай хослуулж ирсэн түүх, хоёр ёсны номлол, Чингис хааны билиг сургаал зэрэг монголын уламжлалт улс төрийн үзэл сургаалиуд ч гэсэн монголын төр ёс болон нийгэмд тодорхой нөлөөлийг үзүүлсээр байх нь дамжиггүй.

<sup>8</sup> Ш Бира “Монголын тэнгэрийн үзэл” 107-р тал УБ 2011

<sup>9</sup> Ш Бира “Монголын тэнгэрийн үзэл” 108-р тал УБ 2011

<sup>10</sup> Н Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” УБ 1995 он 89-р тал.

<sup>11</sup> Н Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” УБ 1995 он 90-р тал. Дам ишлэв.

<sup>12</sup> “Чингисийн сургааль гэрээслэл” УБ 1991. 24-р тал

<sup>13</sup> Тухайлбал Хятадад одоо ч хүртэл маш чанга хатуу ял шийтгэлийн тогтолцоо үйлчилдэг нь легилизмын чанга хатуу ялын бодлогын үзэл сурталтай тодорхой хэмжээгээр холбоотой. /ДС/

## 2. Харизмат легитим шинж

Харизмат засаглал нь удирдагчийн бусдыг өөртөө татах онцгой авьяас чадвар дээр тулгуурладаг бөгөөд шинэ төр засгийг олон түмнээр хүлээн зөвшөөрүүлэхийн тулд уламжлалт үнэт зүйлд түшиглэх, эсвэл олон нийтийн хүсэл зорилгыг ардчилсан аргаар илэрхийлэх боломжгүй байгаа нийгмийн суурь өөрчлөлтийн болон хямрал, эмх замбараагүй үед үүсдэг.

Гэхдээ орчин үеийн улс төрийн шинжлэх ухаанд “Харизм” нь тухайн хувь хүний тэргүүлэгч зан чанарыг илэрхийлдэг учир “Харизм” үгүй хүн гарамгай удирдагч болж чадахгүй хэмээн үздэг. Харизмат засаглалын онцлог шинж нь удирдагчыг бие хүнийх нь хувьд хэт үнэлж, түүний нэр хүндийг засаглалын институтээр хамгаалан бэхжүүлдэг. Тийм учраас харизмат засаглалын ноёрхол нь удирдагч ба олон түмний хооронд үүссэн ихэвчлэн сэтгэл хөдлөл болон хувийн шинжтэй харилцаанд тулгуурладаг ба яваандаа нэг хүнийг тахин шүтэх ганцаар захирах дэглэм руу орох аюултай. Засаглалын харизмат харилцаа үүсэхэд нэг талаас, удирдагчийн онцгой авьяас чадвар, нөгөө талаас олон түмний зүгээс түүнд итгэх нь чухал. Олон түмэн удирдагчаа шүтэж итгэдэг бол удирдагч эх орныг авран хамгаалагчийн дүрдээ тоглох өөрийн чадварт итгэдэг.

Иймээс удирдагч өөртөө бусдыг татах онцгой чадвар буюу харизмат байгааг батлан харуулах, түүнийгээ хадгалах хүсэл эрмэлзэлтэй байдаг.

Харизмат засаглалыг дэмжин тэтгэхэд томоохон ялалт, амжилтыг дагуулдаг удирдагчийн аугаа их үйл хэрэг чухал үүрэгтэй байдаг. Харин онцгой үйл явдал дуусаж нийгэм тогтворжихын хирээр удирдагчийн гайхамшигт чанарт итгэх олон түмний итгэл буурч харизмат засаглалын үр нөлөө аажмаар нурж унадаг байна.

Өгүүллэгийн энэхүү хэсэгт хүн төрөлхтөний түүхэнд суу заль нь хэтийдсэн олон харизмат удирдагчид тухайн цаг үеийн шаардлагаар төрөн гарч байсныг товч дурдахдаа тэдгээрийг хэт магтан өргөмжлөх, Монголд ийм л хүчтэй удирдагч хэрэгтэй гэсэн санааг төрүүлэх зорилгыг тавиагүй болно.

**Чингис хаан /1162-1227/** Монголчууд өөрсдийн дундаас агуу их суут буюу харизматик удирдагчдыг төрүүлэн гаргах талаар суурьшмал иргэншлийн улс түмнээс нэг их дутахааргүй байжээ. Магадгүй аж ахуй, нийгмийн харилцааны хувьд тархай бутархай байдал давамгайлж байдаг нүүдлийн нийгэмд хэтийдсэн суут, харизмат, хүчирхэг удирдагч үе үе илүү их шаардлагатай байсан бөгөөд энэ нь ч тиймэрхүү харизматик удирдагчид нүүдэлчдийн дундаас цөөнгүй гарч байсны нэг учир шалтгаан байж болно. Тэгээд ч XII зууны монголын нийгэм улс төрийн тархай бутархай байдал нь Чингис хаан шиг<sup>14</sup> хүчирхэг харизмат удирдагчийг хүлээн авах хангалттай нөхцлийг бүрдүүлсэн байв.

**Наполеон Бонапарт /1769-1821/** 1799 онд Францад төрийн эргэлт зохион байгуулж, таван жилийн дараа өөрийгөө Францын Эзэн хаанаар өргөмжилсөн.

Тэр цэргүүдийн дунд нэр асар их хүндтэй байсан ба дайны талбарт түүнийг очиход цэргүүд зоригждог байв.

**Адольф Гитлер /1889-1945/** 1923 онд бүтэлгүйтсэн төрийн эргэлтийн дараа шоронд хоригдон гарч ирээд үндсэрхэг үзэл, коммунизмын эсрэг үзлийг өөрийн харизматик илтгэгчийн чадвар, ухуулгаар сурталчлан дэмжлэг олж авч, 1933 онд Германы Канцлераар томилогдож, удалгүй тоталитар фашист дарангуйллыг тогтоосон.

**Франклин Рузвельт /1882-1945/** АНУ-ын 32 дахь ерөнхийлөгч, эдийн засгийн их хямрал болон дэлхийн 2-р дайны үед ард түмнээ удирдсан, АНУ-ын түүхэн дэх хамгийн хүндлэгдсэн ерөнхийлөгчдийн нэг.

**Уинстон Черчилль /1874-1965/** Их Британийн консерватив улс төрч, дэлхийн хоёрдугаар дайны үеийн удирдагч байснаараа олонд танигдсан, Ерөнхий сайдаар хоёр удаа (1940–45 болон 1951–55) ажиллаж байсан, алдартай улс төрийн зүтгэлтэн, уран илтгэгч.

**Махатма Ганди /1869-1948/** Улс төрийн тэмцлийг цус асгаруулсан хүч хэрэглэсэн байдлаар биш харин хүчирхийлэлд үл нэгдсэн, үл хамтарсан байдлаар буюу энх тайванч замаар хийх номлол дэвшүүлэн түүнийгээ хэрэгжүүлж, Энэтхэгийг Английн колониос салгаж бие даасан улс болох үйл хэрэгт их хувь нэмэр оруулсан, дэлхийнэнхтайванч үзэлтэн.

**Мартин Лютер Кинг /1929-1968/** Америкийн санваартан, идэвхтэн, уран илтгэгч, Африк-Америкчуудын иргэний эрхийн хөдөлгөөний гарамгай удирдагч.

<sup>14</sup> Хэрэв түүхэнд үнэхээр ер бусын их суут харизмат удирдагч гэж гарч байсан бол тэр нь юуны өмнө гарцаагүй Чингис хаан байсан гэсэн дүгнэлтийг нэрт академич Ш.Бира гуай хийсэн байдаг.

**Хорлоогийн Чойбалсан** /1895-1952/1930-аад оноос нас барах хүртлээ Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг удирдаж байхдаа их гүрнүүдийн зүгээс бага орны удирдагчид үзүүлдэг дарамт, шахалт бүхий амаргүй хувь тавиланг амссан ч, Монголын тусгаар тогтнолыг тууштай сахин хамгаалах, гадаад бодлогын харьцангуй бие даасан чиг шугамыг баримтлалж байсан Монгол төрийн нэрт зүтгэлтэн.

**Юмжаагийн Цэдэнбал** /1916-1991/Монголын нам, төрийг 44 жил тэргүүлэхдээ улс орноо хөгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, соёлжуулах, улсын тусгаар тогтнол, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх, олон улсад Монголын нэр хүндийг дээшлүүлэхэд өөрийн ухамсарт амьдрал, авьяас чадвар, оюун билгээ зориулсан нам, төрийн зүтгэлтэн.

**Пак Чон Хи** /1917-1979/ 1961 оны 5-р сард цэргийн эргэлтээр засгийн эрхийг гартаа авч улс орныхоо эмх замбараагүй байдлыг эцэс болгож, жараад оны азийн хоцрогдсон газар тариалангийн ядуу буурай орон байсан Солонгосыг орчин үеийн аж үйлдвэржсэн улс болгосон.

**Ли Куан Ю** /1923-2015/ 1959-1990 онд Сингапурын ерөнхий сайдаар тасралтгүй 31 жил ажиллахдаа Чадварлаг засгийн кабинетийг байгуулж, ажилгүйдэл, авилгалтай цогтой тэмцэж, Сингапурыг байгалийн баялаггүй ч хөрөнгөлөг орон болгосон, ард түмэндээ Сингапурын эцэг хэмээн нэрлэгддэг Ли Куан Юзэрэг суу заль нь хэтийдсэн олон харизмат удирдагчид дэлхийн түүхэнд төрөн гарсан юм.

Эндээс дүгнэхэд харизмат засаглал нь нийгэм эдийн засгийн их хямралаас болоод тухайн улс төрийн систем нь нийгэмдээ хүлээн зөвшөөрөгдөхөө больж легитим шинжээ алдаж улс оронд эмх замбраагүй байдал үүсэх үед, эсвэл дайны үед үүсдэг нь тодорхой харагдаж байна. Нийгэм- улс төрийн систем тогтворжих хэрээр харизмат систем нь уламжлалт юм уу, хууль ёсны засаглалд шилждэг.

20-р зуунд харизмат засаглалын гол хэлбэрүүд Италид Муссолини, Германд Гитлер, Англид Черчилль, Америкт Рузвельт, ЗХУ-д Сталины тоталитар дэглэм, Солонгост Ким Ир Сен, Пак Чон Хи, Монголд Чойбалсан, Цэдэнбал нарын засаглалаар илэрч байна. Эдгээр дэглэмүүд нэлээд орнуудын хувьд хуучин нийгмээс орчин үеийн нийгэмд шилжих шилжилтийн үе, уламжлалт нийгмээс коммунист нийгэмд шилжилтийн үед, тэрчлэн нийгэм эдийн засгийн хямралын болоод дайны үед, цаашлаад нэг хүний дарангуйллын нийгмийн үед үүсэн бий болсон. Дээрх дэглэмүүд удирдагчын харизмын тухай олон түмний хуурмаг төсөөлөлд голчлон тулгуурлаж байдаг. Харизмат засаглалын үед олон түмнийг үзэл суртлын хувьд нэгдмэл болгох, боловсруулах, удирдагчын сонгосон үзэл баримтлалыг нийгэмд хязгааргүй ноёрхсон байдалтай болгох бүх аргыг төлөвлөсөн байдаг. Эдгээр дэглэмүүд тодорхой цаг хугацаанд үүсэн бий болж, тодорхой цаг үед үгүй болсон. Өнөөдөр харизмд тулгуурласан нийгэм Хойд Солонгос, Куба зэрэг улс оронд оршсоор байна.

### **3. Хууль ёсны буюу ардчилсан легитим шинж**

Хууль ёсны буюу ардчилсан хэм, хэмжээний дагуу бүрэлдэн бий болсон төрийг хамгийн зөв, шударга гэж үзээд түүнд засаглуулахыг хүлээн зөвшөөрсөн олон түмний итгэл үнэмшил дээр тулгуурласан легитимийн хэлбэр. Энэ шинжийн хувьд уламжлалт зан үйлд биш, онцгой удирдагчид биш, харин ардчилсан дүрэм, журмын дагуу гарсан хуулинд олон түмэн захирагдахаас гадна байнга явагддаг чөлөөт ардчилсан сонгуулийн хүрээнд удирдагчид сонгогдож олон түмнийг төлөөлнө.

Хууль ёсны легитим шинжийн гол онцлог нь төрийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн эрх мэдлийн салаа мөчрүүдэд хувааж тэнцвэржүүлснээс гадна хүний эрхийг үндсэн хуулиар хамгаалсан байдаг учраас олон түмний зүгээс тухайн төр, төрийн байгууламжид итгэх итгэл үнэмшил нь өндөр байдаг талтай. /Д.С/

Хууль ёсны буюу ардчилсан легитим шинжийн ардчилсан болон хууль ёсны гэсэн хоёр тодотгол нь нэг нь нөгөөгөө нөхөн гүйцээж, харилцан холбоотой байдаг боловч агуулгын хувьд давхцадаггүй.

Хуулийн хүрээнд үүсэн бий болж хуулийн хэм хэмжээний дагуу явагдаж байгаа засаглалыг хууль ёсны гэнэ. Гэвч энэ нь бүхэлдээ ардчилсан шинжтэй байж чаддаггүй.

Харин олон түмнээс тодорхой цаг хугацаагаар сонгогдож, олон түмний өмнө хариуцлага хүлээж, олон түмэнд ажлаа тайлагнаж байдаг засаглалыг ардчилсан засаглал гэнэ. Орчин үед аливаа төрийн засаглал нь ардчилсан болон хууль ёсны гэдгийн аль алиныг нь хослуулж байна.

Макс Веберийн легитим шинжийн дээрх гурван хэлбэрээс гадна засаглалын легитимын өөр хэлбэрүүд бий. Ийм нэг хэлбэр бол үзэл суртлын легитим шинж юм.

Энэ нь олон түмний ухамсар, оюун санаанд засаглагч өөрийн үзэл санааны үнэт зүйлсээ шингээн суулгах, итгүүлэх замаар өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх явдал юм. Энд үзэл суртал чухал үүрэг гүйцэтгэнэ. Үзэл суртал нь хэнд хандаж, ямар үүрэгтэй байгаагаас хамаарч нэг бол анги бүлгийн, нэг бол үндэсний эрх ашгийг дээдэлсэн үзэл байж болно. Тухайлбал, социалист гэгдэж байсан орнуудад үзэл суртлын ангийн

хэлбэр өргөн ашиглагдаж байсан бол колони, хараат байсан орнуудад үндэсний үзлийг голчилж байсан байна. Ямар ч төрийн үед үзэл суртлын легитимийн аргыг ашиглаж болно. Ардчилсан төрийн үед иргэдийн улс төрийн соёл, боловсролыг дээшлүүлэх замаар өөрөөр хэлбэл, нийгэмд ноёрхож байгаа нийтлэг, либерал шинжтэй улс төрийн хэм, хэмжээ, үнэлэмжийг хүн бүрт эзэмшүүлэх замаар хэрэгжинэ. Тэгвэл тоталитар, авторитар нийгмийн үед тархи угаах үзэл суртлын тогтолцоогоор дамжин хэрэгжинэ.

Ийнхүү үзэл суртлын легитим шинж нь хүмүүсийн ухамсарт итгүүлж, үнэмшүүлэх эсвэл албадах замаар тухайн засаглалыг хүлээн зөвшөөрүүлж хэрэгжүүлнэ.

Дээр дурьдсан засаглалын легитим шинжийн хэлбэрүүд дангаараа буюу өөр хоорондоо хосолсон байдлаар улс төрийн практикт хэрэгждэг. Улс төрийн практикаас үзэхэд хууль ёсны ба харизмат, уламжлалт ба харизмат, харизмат ба үзэл суртлын гэх мэтээр харилцан хосолсон байх нь түгээмэл байдаг. Засаглалын легитимийн аль ч хэлбэр нь нийгмийн амьдралд үзүүлж байгаа бодитой үр нөлөө, үзүүлж буй үр ашигт чанараараа баталгаажиж чадахгүй бол яваандаа суларч байдаг.

Иргэдээс тухайн засаглалыг хүлээн зөвшөөрч дэмжих явдал нь:

- Үзэл санааны үнэлэмж
- Тухайн засаглал хүмүүст өгч буй, юу өгч чадах вэ?

гэсэн практик үүднээс тодорхойлогддог.

Ийм учраас засаглалын үр ашгийн асуудал нь чухлаар тавигдана.

Засаглалын үр ашиг гэдэг нь тухайн засаглалын үйл ажиллагааны үр дүн, нийгэмд гүйцэтгэж байгаа чиг үүрэг нь хүн ардын хүсэн хүлээж буй үр дүнтэй хэр зэрэг нийцэж байгаагийн бодит тусгал юм.

Засаглалын легитимийн ямар ч хэлбэр эцсийн дүндээ тухайн засаглалын талаарх хүмүүсийн итгэл үнэмшлээр тодорхойлогдоно. Засаглалын үр ашгийг олон үзүүлэлтээр хэмжиж болно. Энд нийгмийн нягтрал, эдийн засгийн хөгжил дэвшил, хүн ардын аж амьдрал, оюун санаа, эрх чөлөө гэх мэт шинж чанарын хувьд олон янзын зүйл хамаарна.

Легитим шинж, засаглалын үр ашиг хоёр холбоотой. Аль нэг нь нөгөөгүйгээр урт удаан оршин тогтнож чаддаггүй. Ер нь засаглалын легитим шинж доройтох, буурах, унах явдал байдаг. Засаглалын легитим шинж алдагдахад дараах хүчин зүйлүүд нөлөөлнө.

- ❖ Ардчилалын түгээмэл үзэл санаа, зарчим болон тухайн улс орон дахь нийгэм, улс төрийн практик хоёрын хоорондын зөрчил. Энэ нь төрийн эрх мэдлийн хуваарилалтыг алдагдуулах, ардчилалыг ёс төдий тунхаглах, шахалт үзүүлэх гэх мэт олон янзаар илэрнэ.
- ❖ Тухайн орны улс төрийн тогтолцоонд ард иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хамгаалах систем байхгүй буюу сул байхад легитим шинж унах нэг шалтгаан болно.
- ❖ Улс орны дотор хүнд суртал, хээл хахууль, гэмт хэрэг өсөн нэмэгдэх. Энэ нь ард түмний бухимдал дургүйцлийг хүргэж легитим шинжийг унагана.
- ❖ Улс орны дотор үндсэрхэг үзэл, угсаатны бүлгүүдийн хоорондын салан тусгаарлах үзэл ухамсар ихсэх нь засаглалын легитим шинжийг унагана.
- ❖ Засаглагч элит нь өөрийн засаглалын хууль ёсны үр ашигтай легитим шинжид үл итгэх явдал нь легитим шинж унах нэг шалтгаан<sup>15</sup> болдог.
- ❖ Нийгэм эдийн засгийн хямралаас улс орноо гаргаж чадахгүй байгаа улс төрийн намууд болоод эрх баригчдын чадваргүй байдал
- ❖ Парламентат ёс гажуудаж, шударга ёс алдагдах

### Дүгнэлт

Эцэст нь дүгнэхэд айдас хүйдэс, албадлага дээр тулгуурласан дэглэм урт удаан хугацаанд оршин тогтнодоггүй гэдгийг дэлхийн түүх бидэнд хангалттай нотолсон. Харин хууль, ёс ардчилсан зарчимд тулгуурласан дэглэм урт удаан хугацаанд оршин тогтнож, засаглалын легитим шинжээ тогтвортой хадгалдаг.

Эртний нийгмийн харилцааг зохицуулж байсан ид шид домын хүчин зүйлүүдээр, эсвэл хүчтэй харизмат лидерийн зан үйлээр орчин үеийн нийгмийн харилцааг зохицуулж болох ч энэ нь урт удаан хугацаанд тогтвортой оршин тогтнох улс төрийн системийн легитим болж чадахгүй.

Энэ үүднээс Монголчууд үндсэн хуулиараа баталгаажуулсан хууль ёст легитим шинжээ улам бүр төгөлдөржүүлж, дарангуйлагч улс төрийн дэглэм руу хальтирч орохгүй байх, дэлхийн болоод монголын түүхэнд гарсан алдаануудыг давтахгүйг хичээх хэрэгтэй атал Монголд хүчтэй лидер хэрэгтэй гэсэн үгийг

<sup>15</sup> Монголын улс төрчид олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өнөөгийн нийгэм эдийн засгийн тухай асуудал хөндсөн сэдвийг ярих болгондоо одоогийн оршин буй улс төрийн систем болоод үндсэн хуулийг өөрчлөх тухай ярьдаг нь олон түмний төрд итгэх итгэлийг алдагдуулах нэг томоохон шалтгаан болж байна. /ДС/

бараг хүн болгон ярьж, энэ нь ч нэлээн газар авч байх шиг. Энэ бол монголын улс төрийн систем хүлээн зөвшөөрөгдөх чадвараа алдаж, легитимийн хомсдолд орсны баталгаа мөн.

Нийгэм эдийн засаг хямарч, иргэдийн амьжиргааны түвшин буурч, шударга ёс алдагдаж, эдийн засгийн хямралаас улс орноо гаргаж чадахгүй байгаа улс төрийн намууд болоод эрх баригчдын чадамж сул байгаа нь ард иргэдийг улам л хүчтэй харизмат лидерийг хүсэмжлэх улс төрийн сэтгэлзүй уруу аваачиж байна.

Харин олны итгэлийг хүлээсэн үндэсний хэмжээний улс төрийн зүтгэлтнүүд болох Путин, Обама, Д.Трам, А.Меркель, Ш.Абэ зэрэг улс төрчид бол ардчилсан сонгуулиар сонгогдож гарч ирдэгээрээ ирнэ.

Монголчууд нэн эрт үеэс төрийг төрийг дээдлэн хувь хүнчлэн ойлгож ирсэн. Иймд улс төрчдийн ажил хэрэгч чанар, ёс суртахууны үлгэр дуурнал олон нийтэд хэмжүүр болж, ажил үйл нь зөв, шударга байх ёстой гэсэн үг. Улс төрчдийн хувийн ашиг сонирхол нь энэ зарчмаас гаждагаас болж засаглалын легитим чанар алдагдаж, улмаар олон түмэн төрийн институтуудад эгдүүцэн дургүйцэх нь нэмэгдэх хандлагатай байна. “Хэрэв захирах зарчим нь ялзарсан бол хамгийн шилдэг хууль ч адгийнх болж төрийн эсрэг хандана, зарчим нь эрүүл байхад адгийн хууль ч сайн хууль мэт үр дагавартай байна. Зарчмын хүч бүхнийг дагуулна” гэж Ш.Л.Монтескье сургасан байдаг.

Өдгөөгийн Монголд олны итгэл, хүндлэлийг хүлээсэн нэр цэвэр, хүн чанартай, үзэл бодолдоо үнэнч, урваж шарвадаггүй, боловсрол мэдлэгтэй шинэ үеийн улс төрийн зүтгэлтнүүдийг нийгэм шаардаад эхэлсэн.

Шинэ үеийн улс төрийн зүтгэлтнүүд л монголын улс төрийн системийг легитимийн хомсдлоос гаргаж чадна. Дэлхий ертөнц уламжлалт болон болон харизмат легитимчлэлээс хууль ёст, ардчилсан легитим шинж руу шилжих шилжилтийг хийчихсэн, бас зарим нь хийж байна. Монгол улс үүнээс хоцрох ёсгүй.

**Резюме:** Природа и основа политической власти в политической науке описываются с помощью понятий «легальность» и «легитимность». Под легальностью понимается законность власти. Понятие же «легитимность», введенное в политологию М. Вебером, трактуется как правомочность власти, ее поддержка со стороны общества, проявление лояльности к власти со стороны граждан. Вебер утверждал, что характер легитимности власти (господства) определяет ее природу. Согласно Веберовской теории, существуют три типа легитимного господства. Традиционный тип господства характеризуется подчинением общества власти в силу традиций, обычаев и привычки. Как правило, подданные непосредственно зависели от воли своего владыки, который осуществлял непосредственный контроль за исполнением своих распоряжений. Харизматический тип господства (от греч. charisma – божественный дар) основывается на вере в необыкновенные качества, свойства личности. Харизматическое господство возникает в условиях социально-политического кризиса. Он способствует появлению вождей, идущих навстречу духовным потребностям масс, приписывающих вождям необыкновенные свойства. Рационально-легальный тип господства основывается на убеждении в необходимости подчинения принципам правового порядка и юридическим нормам. В демократическом обществе и государстве должна господствовать власть права, основанная на свободе, культуре и интересах народа, отдельной личности. Рационально-легальная легитимность основывается на вере участников политической жизни в справедливость существующих в Монгольском политическом системе.

#### НОМ ЗҮЙ:

1. Ш. Бира “Монголын тэнгэрийн үзэл” УБ 2011
2. Н.Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” УБ 1995 он
3. “Чингисийн сургаал гэрээслэл” УБ 1991
4. МУИС “Улс төрийн шинжлэх ухаан” УБ 2001
5. Чөлөөт нэвтэрхий толь- Википедиа
6. Ц.Зориг “Сүүлчийн долоон жил “1993 он
7. Гэрэл сүүдэр: “Ю.Цэдэнбалын хувийн тэмдэглэлээс. 1992 он”
8. Вебер.М. Избранное произведение. М., 1990.
9. Ачкасов В.А., Елисеев С.М., Ланцов С.А. Легитимность
10. Монтескье. О духе законов. История политических и правовых учений. М., 1995, с. 281-289.